



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/312

Чингис хот

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 18.3.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 2020 сны 6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Мах-сүүний хосолмол ашиг шимтэй Дадал сумын үхрийн "Үүлдэр хэсэгт" тодорхойлолт бичих судалгааны ажилд 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгй.

2 Дээрх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа), захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011678